

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/017/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ӨСӨХ НАХИА ЦОГЦОЛБОР
ЦЭЦЭРЛЭГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК захирал:

Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/193
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР
СУМЫН ӨСӨХ НАХИА ЦОГЦОЛБОР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ҮРЖИНХАНД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 34,000.0 мянган төгрөг, Борнуур сумын Засаг даргын нөөцөөс 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээр Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвд “Бүрд оржих дриллинг” ХХК худаг гаргаж, цэвэр усны асуудлыг шийдвэрлэсэн байна.

Аудитын гол асуудал

Борнуур сумын Засаг даргын Тамгын газрын давсан хөрөнгөөс төв цэцэрлэгт 9,364.0 мянган төгрөг, салбар цэцэрлэгт 6,236.0 мянган төгрөг нийт 15,600.0 мянган төгрөгийн бүрэн камержуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 86.05 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4176020227

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	370,796,040.16	134,482,538.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	314,738,039.37	68,917,747.73
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	314,738,039.37	68,917,747.73
3121	Төгрөг	314,738,039.37	68,917,747.73
31211	Төрийн сангийн харилцах	314,738,039.37	68,917,747.73
35	БАРАА МАТЕРИАЛ	56,058,000.79	65,564,790.79
354	Хангамжийн материал	56,058,000.79	65,564,790.79
35410	Бичиг хэргийн материал	2,240,900.00	5,525,100.00
35420	Аж ахуйн материал	52,241,530.79	56,239,030.79
35440	Түлш, шатах тослох материал	838,400.00	838,400.00
35460	Хүнсний материал	737,170.00	2,962,260.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	761,476,470.65	802,903,908.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	761,476,470.65	802,903,908.35
392	Биет хөрөнгө	699,722,470.65	739,049,908.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	999,922,634.65	999,922,634.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(346,468,916.76)	(387,159,063.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,736,757.70	82,529,548.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,173,013.70)	(17,441,576.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,366,902.99	50,679,399.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,421,644.63)	(6,987,420.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,618,309.21	29,463,569.91
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,777,208.81)	(12,875,833.37)
39217	Ном	918,650.00	918,650.00
393	Биет бус хөрөнгө	61,754,000.00	63,854,000.00
39301	Програм хангамж	160,000.00	2,260,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(160,000.00)	(160,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	61,754,000.00	61,754,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,132,272,510.81	937,386,446.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	213,500.00	1,021,713.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	213,500.00	1,021,713.00
413	Өглөг	213,500.00	1,021,713.00
4136	Бусад өглөг	213,500.00	1,021,713.00
41361	Байгууллагад төлөх өглөг	213,500.00	728,450.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	293,263.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,132,059,010.81	936,364,733.87
51	Засгийн газрын хувь оролцоо	1,132,059,010.81	936,364,733.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	171,229,673.50	171,229,673.50
51101	Өмч: - төрийн	171,229,673.50	171,229,673.50
512	Хуримтлагдсан үр дүн	626,056,071.75	430,361,794.81
51210	Өмнөх үеийн үр дүн	626,056,071.75	626,056,071.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	(195,694,276.94)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	334,773,265.56	334,773,265.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,132,272,510.81	937,386,446.87

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,331,633,699.97	1,054,793,238.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,512,113.00	72,305,038.49
120	Нийтлэг татварын бус орлого	128,512,113.00	72,305,038.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,203,121,586.97	982,488,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,080,756,300.00	856,766,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,080,756,300.00	856,766,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,365,286.97	125,722,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,365,286.97	125,722,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,090,644,011.93	1,250,487,515.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,090,644,011.93	1,250,487,515.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,090,644,011.93	1,249,871,262.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	669,346,596.47	843,972,532.90
210101	Үндсэн цалин	470,604,617.49	547,349,772.31
210102	Нэмэгдэл	198,741,978.98	280,856,707.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,135,000.00
210104	Урамшуулал	-	9,631,052.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,915,210.21	105,158,541.74
210201	Тэтгэврийн даатгал	57,433,200.61	71,893,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,824,775.50	8,460,603.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,308,437.72	4,222,371.79
210204	Ажилгүйдлийн даатгал	3,243,270.35	4,221,029.66
210205	Эрүүл мэндийн даатгал	13,105,526.03	16,361,236.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,486,536.97	122,713,046.77
210301	Гэрэл, цахилгаан	12,601,186.53	15,598,615.88
210302	Түлш, халаалт	104,242,150.44	104,169,750.00
210303	Цэвэр, бохир ус	3,643,200.00	2,944,680.89
2104	Хангамж, бараа материалын зардал	8,956,400.00	7,810,850.00
210401	Бичиг хэрэг	6,153,100.00	5,001,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,794,300.00	2,808,950.00
210404	Ном, хэвлэл	9,000.00	-
2105	Нормативт зардал	107,056,941.00	110,645,590.00
210502	Хоол, хүнс	99,814,531.00	102,919,440.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,242,410.00	7,726,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,394,200.00	3,930,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,394,200.00	3,930,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,488,127.28	52,640,700.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,636,000.00	5,709,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,852,127.28	46,930,900.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	616,253.23
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	616,253.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	240,989,688.04	(195,694,276.94)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	240,989,688.04	(195,694,276.94)

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,203,121,586.97	982,488,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,203,121,586.97	982,488,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,080,756,300.00	856,766,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,080,756,300.00	856,766,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,365,286.97	125,722,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,365,286.97	125,722,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,006,492,348.65	1,210,438,938.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,006,492,348.65	1,210,438,938.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,006,492,348.65	1,210,438,938.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	669,346,596.47	843,679,269.90
210101	Үндсэн цалин	470,604,617.49	547,056,509.31
210102	Нэмэгдэл	198,741,978.98	280,856,707.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,135,000.00
210104	Урамшуулал	-	9,631,052.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,915,210.21	105,158,541.74
210201	Тэтгэврийн даатгал	57,433,200.61	71,893,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,824,775.50	8,563,429.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,308,437.72	4,119,545.85
210204	Ажилгүйдлийн даатгал	3,243,270.35	4,221,029.66
210205	Эрүүл мэндийн даатгал	13,105,526.03	16,361,236.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,365,286.97	122,105,846.77
210301	Гэрэл, цахилгаан	12,601,186.53	15,598,615.88
210302	Түлш, халаалт	104,120,900.44	104,169,750.00
210303	Цэвэр, бохир ус	3,643,200.00	2,337,480.89
2105	Нормативт зардал	95,950,895.00	105,144,530.00
210502	Хоол, хүнс	95,950,895.00	105,144,530.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,794,200.00	3,965,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,794,200.00	3,965,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,120,160.00	27,385,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,751,800.00	19,332,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,368,360.00	8,053,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	196,629,238.32	(227,950,738.41)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,754,750.00	17,253,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,754,750.00	17,253,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,754,750.00	17,253,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,754,750.00	17,253,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,754,750.00)	(17,253,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	187,874,488.32	(245,204,038.41)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	126,863,551.05	314,738,039.37
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	314,738,039.37	68,917,747.73

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	171,229,673.50	334,773,265.56	384,994,383.71	890,997,322.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	171,229,673.50	334,773,265.56	384,994,383.71	890,997,322.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	240,989,688.04	240,989,688.04
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	171,229,673.50	334,773,265.56	626,056,071.75	1,132,059,010.81
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	171,229,673.50	334,773,265.56	626,056,071.75	1,132,059,010.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	171,229,673.50	334,773,265.56	626,056,071.75	1,132,059,010.81
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(195,694,276.94)	(195,694,276.94)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	171,229,673.50	334,773,265.56	430,361,794.81	936,364,733.87

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	991,995,800.00	981,871,946.77	10,123,853.23	99.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	125,722,100.00	125,105,846.77	616,253.23	99.5
132001	Орон нутгийн төсвөөс	125,722,100.00	125,105,846.77	616,253.23	99.5
1310	УЛСЫН ТӨВЛӨРСӨН САНХҮҮЖИЛТ	866,273,700.00	856,766,100.00	9,507,600.00	98.9
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	866,273,700.00	856,766,100.00	9,507,600.00	98.9
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,290,673,500.00	1,227,692,238.41	62,981,261.59	95.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,290,673,500.00	1,227,692,238.41	62,981,261.59	95.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,290,673,500.00	1,227,692,238.41	62,981,261.59	95.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	879,792,800.00	843,679,269.90	36,113,530.10	95.9
210101	Үндсэн цалин	583,676,400.00	547,056,509.31	36,619,890.69	93.7
210102	Нэмэгдэл	284,342,200.00	280,856,707.75	3,485,492.25	98.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,135,000.00		
210104	Урамшуулал	11,774,200.00	9,631,052.84	2,143,147.16	81.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,587,900.00	105,158,541.74	4,429,358.26	96.0
210201	Тэтгэврийн даатгал	74,351,700.00	71,893,300.00	2,458,400.00	96.7
210202	Тэтгэмжийн даатгал	8,809,100.00	8,460,603.55	348,496.45	96.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,404,500.00	4,222,371.79	182,128.21	95.9
210204	Ажилгүйдлийн даатгал	4,404,500.00	4,221,029.66	183,470.34	95.8
210205	Эрүүл мэндийн даатгал	17,618,100.00	16,361,236.74	1,256,863.26	92.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,722,100.00	122,105,846.77	616,253.23	99.5
210301	Гэрэл, цахилгаан	16,152,100.00	15,598,615.88	553,484.12	96.6
210302	Түлш, халаалт	104,170,000.00	104,169,750.00	250.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,337,480.89	62,519.11	97.4
2105	Нормативт зардал	125,333,000.00	105,144,530.00	20,188,470.00	83.9
210502	Хоол, хүнс	125,333,000.00	105,144,530.00	20,188,470.00	83.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,069,100.00	6,065,000.00	4,100.00	99.9
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	6,069,100.00	6,065,000.00	4,100.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,168,600.00	42,539,050.00	1,629,550.00	96.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,783,900.00	32,175,950.00	1,607,950.00	95.2
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	10,384,700.00	10,363,100.00	21,600.00	99.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		314,738,039.37		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		68,917,747.73		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 85,235.8 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын 5 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгийн 32,883.7 мянган төгрөгийг Тодруулга тайланд хандиваар гэж буруу тусгасан байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материалын 1,200.0 мянган төгрөгийг Тодруулга тайланд хандиваар гэж буруу тусгасан байна.
- Бичиг хэргийн материалын данснаас зардлын ангиллыг буруу зааснаас үр дүнгийн тайлан 2,862.6 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн.
- Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 01/231 дүгээр тогтоолын дагуу ашиглах хугацаа сунгах, үнэ шинэчлэн тогтоосон 77 ширхэг 38,221.2 мянган төгрөгийн хөрөнгийг буруу бүртгэсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн 808.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 5,820.4 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2 Залруулаагүй зөрчил

Аудитаар нийт 808.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 3 зөвлөмж хүргүүлээ.

5.2.2 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 243 ширхэг 53,149.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, бүртгэх зөвлөмж өгөв.

3.Өглөгийн данстай асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст 808.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үүссэн өглөгийг бүрэн барагдуулах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн төсвийн хөрөнгөөр авсан хөрөнгө нь мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгөөс 10,068.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна	1	10,068.3			1	10,068.3	1	10,068.3		
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгийн 32,883.7 мянган төгрөгийг Тодруулга тайланд хандиваар гэж буруу тусгасан байна.	1	32,883.7			1	32,883.7	1	32,883.7		
3	Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материалын 1,200.0 мянган төгрөгийг Тодруулга тайланд хандиваар гэж буруу тусгасан байна.	1	1,200.0			1	1,200.0	1	1,200.0		
4	Бичиг хэргийн материалын данснаас зардлын ангиллыг буруу зааснаас үр дүнгийн тайлан 2,862.6 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн.	1	2,862.6			1	2,862.6	1	2,862.6		
5	Төв аймгийн Орон нутгийн Өмчийн газрын 2025 оны 01/231 дугаар тогтоолын дагуу ашиглах хугацаа сунгах, үнэ шинэчлэн тогтоосон 77 ширхэг 38,221.2 мянган төгрөгийн хөрөнгийг буруу бүртгэсэн байна.	1	38,221.2			1	38,221.2	1	38,221.2		
	Дүн	5	85,235.8			5	85,235.8	5	85,235.8		

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	-							1	-				
2	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 86 ширхэг 498,752.5 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-							1	-				
3	Тайлант хугацааны эцэст 808.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	808.2							1	808.2				
	Дүн	3	808.2							3	808.2				

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 140 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 12 мэдээлэл, байршуулаагүй 19 мэдээлэл байна. Шилэн дансны тухай хуулийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 500,890.8 мянган төгрөгийн 15 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 415,956.4 мянган төгрөгийн 21 гүйлгээ, зарлагын 59,028.7 мянган төгрөгийн 9 гүйлгээ тус тус байршуулаагүй байна.	1	975,876.1	-	-	1	975,876.1	-	-
Нийт дүн	1	975,876.1			1	975,876.1		

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 63-20810579-ТӨА-2026/017/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэг нь тайлант онд нийт 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 168 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 930,493.6 мянган төгрөгийн 21 гүйлгээ, зарлагын 109,168.2 мянган төгрөгийн 10 гүйлгээ тус тус хугацаа хоцроож, зарлагын 10,390.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-д "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг зогсоож биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Борнуур сумын Өсөх нахиа цогцолбор цэцэрлэгийн эрхлэгч С.Дулмаа, нягтлан бодогч О.Баяржаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn